

НЭЭЛТТЭЙ НИЙГЭМ ФОРУМ

МОНГОЛ УЛСЫН 2016 ОНЫ ТӨСВИЙН ТӨСӨЛ

ТОЙМ ДҮГНЭЛТ

Боловсруулсан:

Судлаач П. Хишигбаяр

ШУТИС-БуХС-ийн багш, докторант Д. Баярмаа

Хянан тохиолдуулсан:

доктор Д.Оюунбадам

2015 оны 11-р сар

АГУУЛГА

ХУРААНГУЙ.....	1
НЭГ. 2016 ОНЫ ОЛОН УЛСЫН ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДАЛ.....	2
ХОЁР. УУЛ УУРХАЙ, ЭРДЭС БАЯЛАГ, ТҮҮХИЙ ЭДИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН ТӨЛӨВ БАЙДАЛ.....	6
ГУРАВ. 2016 ОНЫ НЭГДСЭН ТӨСВИЙН ТАНИЛЦУУЛГА.....	9
ДӨРӨВ. 2016 ОНЫ НЭГДСЭН ТӨСВИЙН ОРЛОГЫН ШИНЖИЛГЭЭ.....	12
ТАВ. 2016 ОНЫ НЭГДСЭН ТӨСВИЙН ЗАРЛАГЫН ШИНЖИЛГЭЭ.....	15
ЗУРГАА. МАКРО ЭДИЙН ЗАСГИЙН ТЭНЦВЭР БА НЭГДСЭН ТӨСӨВ.....	21
ДОЛОО. ЗАСГИЙН ГАЗРЫН ӨРИЙН УДИРДЛАГА БА ОЛОН УЛСЫН БАЙГУУЛЛАГУУДЫН БАЙР СУУРЬ.....	27
НАЙМ. ЕРӨНХИЙ ДҮГНЭЛТ БА ЗӨВЛӨМЖ.....	30

ТОВЧИЛСОН ҮГСИЙН ЖАГСААЛТ

ААНОАТ	–	Аж ахуй нэгжийн орлогын албан татвар
АНУ	–	Америкийн Нэгдсэн Улс
АМНАТ	–	Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр
БНХАУ	–	Бүгд Найрамдах Хятад Ард Улс
ГВАН	–	Гадаад валютын албан нөөц
ГШХО	–	Гадаадын шууд хөрөнгө оруулалт
ГЦА	–	Гадаад цэвэр актив
ДНБ	–	Дотоодын нийт бүтээгдэхүүн
ЗГ	–	Засгийн газар
НДШ	–	Нийгмийн даатгалын шимтгэл
НӨАТ	–	Нэмэгдсэн өртгийн албан татвар
ННФ	–	Нээлттэй нийгэм форум
ОТТ	–	Оюу толгой төсөл
ОУВС	–	Олон улсын валютын сан
ӨҮЦ	–	Өнөөгийн үнэ цэнэ
ТӨҮГ	–	Төрийн өмчит үйлдвэрийн газар
ХО	–	Хөрөнгө оруулалт
ХБГ	–	Хүлээгдэж буй гүйцэтгэл
ХХОАТ	–	Хувь хүний орлогын албан татвар
УИХ	–	Улсын Их Хурал
УУ	–	Уул уурхай
ҮАГ	–	Үндэсний Аудитын Газар
ҮСХ	–	Үндэсний Статистикийн Хороо

ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт 1.	Дэлхийн зарим улс орнуудын засгийн газрын нийт зарлагын ДНБ-д эзлэх хувийн харьцуулалт	20
Хүснэгт 2.	Монгол Улсын өрийн тогтвортой байдлын үзүүлэлт (таамаглал)	29
Хүснэгт 3.	Монгол Улсын зээлжих зэрэглэл	29

ЗУРГИЙН ЖАГСААЛТ

Зураг 1.	Дэлхийн улс орнуудын 2016 оны эдийн засгийн төлөв байдал	2
Зураг 2.	Худалдан авалтын менежерийн индекс (PMI)	3
Зураг 3.	БНХАУ-ын макро эдийн засгийн үзүүлэлтүүдийн динамик	4
Зураг 4.	“Шинэ Хятад” төлөвлөгөө: Голлох шинэчлэл	4
Зураг 5.	БНХАУ-ын бүс нутгийн хөгжлийн төлөвлөгөө	5
Зураг 6.	Зэсгийн үнийн динамик	6
Зураг 7.	Нүүрсний үнийн динамик	6
Зураг 8.	Түүхий газрын тосны үнийн динамик	7
Зураг 9.	БНХАУ-ын импортолж буй төмрийн хүдрийн үнийн динамик	7
Зураг 10.	Олон улсын нүүрсний өрсөлдөөн	8
Зураг 11.	2016 оны нэгдсэн төсвийн орлого ба зардал	9
Зураг 12.	2016 оны нэгдсэн төсвийн тэнцэл	9
Зураг 13.	2015, 2016 оны нэгдсэн төсвийн харьцуулалт	10
Зураг 14.	Түүхий эдийн үнийн цикл ба Монгол Улсын төсвийн төлөвлөлт	10
Зураг 15.	Монгол Улсын төсвийн төлөвлөлт	11
Зураг 16.	2016 оны нэгдсэн төсвийн урсгал орлогын бүтэц	12
Зураг 17.	Уул уурхайн салбарын орлогоос хамаарах хамаарал	13
Зураг 18.	Уул уурхайн татварууд (голлох татварын төрлүүдээр)	13
Зураг 19.	Уул уурхайн салбарын орлогын төлөвлөлт	14
Зураг 20.	Нэгдсэн төсвийн нийт зарлага ба цэвэр зээл	15
Зураг 21.	2016 оны нэгдсэн төсвийн урсгал зарлага	16
Зураг 22.	Бүтцийн өөрчлөлтийн дүнд буурах орон тоо, урсгал зардал	16
Зураг 23.	Зээлийн үйлчилгээний төлбөр	17
Зураг 24.	Засгийн газрын 28 долоо хоногийн хугацаатай үнэт цаасны хүү	17
Зураг 25.	2016 оны нэгдсэн төсвийн хөрөнгийн зардал	18
Зураг 26.	Улсын төсөв болон Хөгжлийн банкны эх үүсвэрээр хийгдэж буй хөрөнгө оруулалтын хэмжээ	18
Зураг 27.	Улсын төсвөөс санхүүжих хөрөнгө оруулалт	19
Зураг 28.	Улсын төсвөөс эргэн төлөгдөх нөхцөлтэй Хөгжлийн банкны эх үүсвэрээс санхүүжих хөрөнгө оруулалт (салбараар)	19
Зураг 29.	Урсгал зардал ба хөрөнгийн зардлын хуваарилалт	20
Зураг 30.	Нэгдсэн төсвийн тэнцэл	21
Зураг 31.	Нэгдсэн төсвийн алдагдал	22
Зураг 32.	Мөнгөний нийлүүлэлт ба бизнесийн идэвх	22
Зураг 33.	Бодит ДНБ ба суурь инфляцийн өсөлт	23
Зураг 34.	Мөнгөний нийлүүлэлт ба гадаад валютын нөөц	23
Зураг 35.	Монголбанкны гадаад өр	24
Зураг 36.	Түүхий эдийн валютуудын ам.доллартай харьцах ханш	25
Зураг 37.	Валютын ханшийн төсөвт үзүүлэх нөлөөлөл	26
Зураг 38.	Засгийн газрын өрийн үлдэгдэл	27
Зураг 39.	Засгийн газрын нийт гадаад өрийн эргэн төлөлт	27
Зураг 40.	Монгол Улсын бодлого ба институцийн чадавхийн үнэлгээ	28
Зураг 41.	Засгийн газрын гадаад өрийн хямралд орох эрсдэлтэй орнууд	29

ХУРААНГУЙ

Нээлттэй Нийгэм Форумгаас жил бүр Монгол Улсын нэгдсэн төсвийн төсөлд тойм шинжилгээ хийж үр дүнг нь бодлого боловсруулагчид, судлаачид, хэвлэл мэдээллийнхэн, иргэд, олон нийтэд танилцуулдаг.

Зөвлөх баг Нээлттэй Нийгэм Форумтай байгуулсан гэрээний дагуу Монгол Улсын 2016 оны Нэгдсэн төсвийн төсөлд хийсэн тойм дүгнэлтийг 2015 оны 10-р сарын 12-ноос 2015 оны 11-р сарын 05-ны хооронд боловсруулсан болно.

Зөвлөх багийн боловсруулсан тойм дүгнэлтэд дараах мэдээллүүд багтсан. Үүнд:

- 2016 оны олон улсын эдийн засгийн төлөв байдал
- Уул уурхай, эрдэс баялаг, түүхий эдийн зах зээлийн төлөв
- Монгол Улсын 2016 оны нэгдсэн төсвийн орлогын шинжилгээ
- Монгол Улсын 2016 оны нэгдсэн төсвийн зарлагын шинжилгээ
- Макро эдийн засгийн тэнцвэр ба нэгдсэн төсвийн тэнцэл
- Засгийн газрын өрийн тойм, Олон улсын байгууллагуудын байр суурь

Тайлангийн үндсэн зорилго нь төсвийн мэдээллийг бодлого боловсруулагчид болон иргэд, олон нийтэд хүртээмжтэй, шинжилгээ, дүгнэлт бүхий байдлаар богино хугацаанд танилцуулах явдал юм. Мөн Монгол Улсын эдийн засгийн нөхцөл байдалтай төсвийн төсөл хэрхэн уялдаж байгаад хараат бус, хөндлөнгийн дүгнэлт өгөхөд оршино.

Энэхүү танилцуулгыг боловсруулахдаа Сангийн яамны төсвийн мэдээллүүд, Монголбанк, Үндэсний Статистикийн Хороо, Олон Улсын Валютын Сан, Дэлхийн банк, Credit Suisse, JP Morgan, Goldman Sachs, UBS, Mckinsey&Co болон бусад олон улсын судалгааны байгууллагуудаас эмхтгэн гаргасан тайлангууд болон тоон мэдээллүүдэд тулгуурлав.

Энэхүү танилцуулга нь Нээлттэй Нийгэм Форумын албан ёсны байр суурь биш бөгөөд гагцхүү хувь судлаачдын байр суурийг илтгэнэ.


НЭГ. 2016 ОНЫ ОЛОН УЛСЫН ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДАЛ

2016 онд Дэлхийн эдийн засгийн төлөв байдал төдийлөн сайжрахгүй байх төлөвтэй байна.

ОУВС-ийн 2015 оны 10-р сарын “Дэлхийн эдийн засгийн тойм”-д БНХАУ болон хөгжиж буй орнуудын эдийн засгийн удаашралаас шалтгаалан дэлхийн эдийн засгийн өсөлт 2015 онд 2007 оны санхүүгийн хямралаас хойш хамгийн бага хувь буюу 3.1 хувьтай байх тухай дурьджээ. 2016 онд дэлхийн эдийн засгийн дундаж өсөлт 3.6 хувь, хөгжингүй улс орнуудын эдийн засгийн өсөлт 2.2 хувь, хөгжиж буй улс орнуудын эдийн засгийн өсөлт 4.5 хувь байхаар таамагласан байна. ОУВС-ийн таамаглалаар 2016 оны эдийн засгийн өсөлтийг зарим голлох улс орнуудаар авч үзвэл АНУ 2.8 хувь, Евро бүс 1.6 хувь, Япон 1 хувь, Их Британи 2.2 хувь, Канад 1.7 хувь, ОХУ -0.6 хувь, БНХАУ 6.3 хувь, Энэтхэг 7.5 хувь, Латин Америк ба Карибын тэнгисийн орнууд 0.8 хувь, Ойрхи Дорнод ба Хойд Африкийн орнууд 3.9 хувь, Саб Сахарын Африкийн орнууд 4.3 хувийн өсөлттэй байх ажээ (Зураг 1).

Хөгжиж буй орнуудын эдийн засгийн өсөлт 2010 оноос хойш тав дахь жилдээ дараалан буурч байгаа бөгөөд энэ нь дэлхийн эдийн засгийн нийт өсөлт буурахад нөлөөлж байна. ОУВС-аас БНХАУ-ын эдийн засгийн өсөлтийн удаашрал, түүхий эдийн ханшийн сулрал, долларын ханшийн өсөлт зэрэг нь хөгжиж буй орнуудын эдийн засгийн өсөлтийг цаашид дахин бууруулах эрсдэлтэйг анхааруулж, дотоодын эдийн засгийн худалдан авах чадварыг нэмэгдүүлж, эдийн засгийн өсөлтийг дэмжих бодлогын шинэчлэл хийх шаардлагатайг анхааруулжээ.

Зураг 1. Дэлхийн улс орнуудын 2016 оны эдийн засгийн төлөв байдал




Эх сурвалж: Дэлхийн Эдийн засгийн Тойм 2015-10 сар, ОУВС; Санхүүгийн Тогтвортой байдлын тайлан 2015-10 сар, Bloomberg Financial Conditions Index, Goldman Sachs Financial Conditions Index, Монгол улсын ҮСХ, Дэлхийн банкны дата сан, Судалгааны багийн дүн шинжилгээ

Дэлхийн санхүүгийн хямралын гуравдагч давлагаа хөгжиж буй орнуудыг дайрч байна.

Дэлхийн санхүүгийн хямралын гуравдагч давлагаа¹ хөгжиж буй орнуудад нөлөөлж байгааг олон улсын байгууллагуудаас Худалдан авалтын менежерийн индекс (PMI- Purchasing Managers' Index)-ийн уналтаар тодорхойлж байна. Худалдан авалтын менежерийн индекс (PMI) нь аж үйлдвэрийн салбарын эрүүл байдлыг харуулдаг бөгөөд уг үзүүлэлт 50-аас дээш хувьтай байвал тухай орны аж үйлдвэрийн салбарын эдийн засгийн байдал эрүүл гэж үздэг. 2015 оны 9-р сарын байдлаар ОХУ, Энэтхэг, БНХАУ, Өмнөд Солонгос, Тайвань зэрэг хөгжиж буй орнуудад Худалдан авалтын менежерийн индекс (PMI) 50-аас доош хувь руу буурсан байна (Зураг 2). Хөгжиж буй улс орнуудын гадаад орнуудаас худалдан авах, импортлох түүхий эдийн хэмжээ буурч, эдийн засгийн өсөлт гинжин урвалаар саарч байна гэж олон улсын байгууллагууд дүгнэжээ.

Зураг 2. Худалдан авалтын менежерийн индекс* (PMI)



Эх сурвалж: Goldman Sachs, FactSet, Markit, J.P. Morgan Asset Management, Зах Зээлийн Хөтөч судалгаа-2015, Судалгааны багийн дүн шинжилгээ.

* Дэлхийн PMI –ийг тооцохдоо ДНБ-ий жигнэсэн дунджаар дүйцүүлсэн болно. Бүх тоон мэдээ 2015 оны 9-р сарын 31-ний байдлаар

БНХАУ-ын эдийн засгийн өсөлт удааширч, хөгжлийн загвараа өөрчлөн, бүтцийн өөрчлөлт хийж эхлээд байна.

2016 онд БНХАУ-ын эдийн засгийн өсөлт 6-7 хувь байна гэж Дэлхийн банк, ОУВС зэрэг олон улсын байгууллагууд болон тус улсын эрх баригчид таамагласан байна. Энэ нь дэлхийн бусад улс орнуудтай харьцуулахад харьцангуй өндөр өсөлт боловч 2011 он хүртэл ДНБ-ий хэмжээ нь хориод жилийн турш жил бүр 10-аас дээш хувиар өсөж ирсэн БНХАУ-ын хувьд маш доогуур үзүүлэлт юм. БНХАУ-ын экспорт, импорт, хувийн хэрэглээ, хөрөнгө оруулалт, аж үйлдвэрийн бүтээгдэхүүний үйлдвэрлэл зэрэг макро эдийн засгийн голлох үзүүлэлтүүд буурч байна (Зураг 3). Түүхий эдийн гол худалдан авагч БНХАУ-ын эдийн засгийн өсөлтийн удаашрал нь Ази, Латин Америк, Африкийн түүхий эд экспортлогч хөгжиж буй орнуудад сөрөг нөлөө үзүүлж байна.

¹ Дэлхийн санхүүгийн хямралын 1 дэх давлагаа АНУ-ын орон сууцны хямрал, 2 дахь давлагаа Евро бүсийн өрийн хямрал


Зураг 3. БНХАУ-ын макро эдийн засгийн үзүүлэлтүүдийн динамик



Эх сурвалж: БНХАУ-ын Улсын Статистикын Төв хороо, Рио Тинто Хэвлэлийн Мэдээлэл, Бээжин Axis, Credit Suisse Core Views/Sep-10/2015, Судалгааны багийн дүн шинжилгээ


Цаашид БНХАУ-ын эдийн засгийн өсөлт өмнөх өндөр түвшиндээ хүрэхгүй гэж олон улсын шинжээчид үзэж байгаа бөгөөд БНХАУ эдийн засгаа илүү бага хурдацтай өсөлтөд тохируулахын тулд хөгжлийн загвараа өөрчлөн, бүтцийн өөрчлөлт хийх шаардлагатай тулгараад байна (Зураг 4).

Зураг 4. “Шинэ Хятад” төлөвлөгөө: Голлох шинэчлэл



БНХАУ-ын удирдлагууд хөрөнгө оруулалтыг бүс нутгийнхаа баруун тийш чиглүүлэн эдийн засгийн өсөлтөө хадгалах, цаашид бууруулахгүй байхаар төлөвлөж байна (Зураг 5). Монгол улс БНХАУ-ын эдийн засгийн өсөлтийн халил (spill over)²-аас хүртэх боломжийг тусгайлан судалж бүс нутаг, аймаг орон нутгуудын хөгжлийн төлөвлөлттэй уялдуулах шаардлагатай байна. Нэгдсэн төсвийн төслийг боловсруулахдаа хөрш орнуудын эдийн засгийн төлөвлөлт болон бусад хүчин зүйлсийг анхааралтай судалж, дунд, урт хугацааны хөрөнгө оруулалтын стратегитай уялдуулах хэрэгтэй.

Зураг 5. БНХАУ-ын бүс нутгийн хөгжлийн төлөвлөгөө



Эх сурвалж: Бээжин Axis, McKinsey, БНХАУ-ын хотуудын хөгжлийн дүн шинжилгээ судалгаа, Монгол Улсын Зам Тээврийн яам

² Дэлхийн улсуудын дунджаар хөрш орнуудын эдийн засаг нь нэг хувиар өсөхөд тухайн улсад 0.4 хувийн нэмэлт өсөлт ирдгийг Paul Collier (The Bottom Billion (2007)) судалж тогтоосон байдаг.

ХОЁР. УУЛ УУРХАЙ, ЭРДЭС БАЯЛАГ, ТҮҮХИЙ ЭДИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН ТӨЛӨВ БАЙДАЛ

2011 оноос хойш тасралтгүй унаж буй түүхий эдийн зах зээлийн төлөв тодорхойгүй хэвээр байна.

2007 – 2009 оны дэлхийн санхүүгийн хямралын дараа эрдэс бүтээгдэхүүн, уул уурхайн түүхий эдийн үнэ огцом сэргэсэн боловч Европын өрийн хямрал болон олон улсын зөрчилдөөнт нөхцөл байдлуудын улмаас дахин унаж, 2009 оны үетэй ижил нөхцөл бий боллоо.

Ялангуяа зэсийн үнийн хувьд 4 жил дараалан буюу нийт 47%-иар буурч дэлхийн санхүүгийн хямралын 2008 оны үетэй ижил 5000 ам.долларт хүрээд байна. ОУВС болон бусад томоохон судалгааны байгууллагуудаас гаргасан таамаглалаар 2017 он хүртэл нөхцөл байдал сайжрахгүй гэж дүгнэсэн байна (Зураг 6).


Зураг 6. Зэсийн үнийн динамик



Эх сурвалж: ОУВС, Рио Тинто, 2015/9 сар, Дэлхийн Түүхий Эдийн Зах Зээлийн Тойм 2015/10 сар, UBS Metal Insight

Эрчим хүч, ган боловсруулалтын үндсэн орц болох нүүрсний үнэ мөн уналттай байна. Нүүрсний үнэ өмнөх оны мөн үеэс 25%-иар буурсан бөгөөд БНХАУ-ын эдийн засгийн удаашрал, дэлхийн улс орнуудын нүүрснээс татгалзах хандлага зэрэг хүчин зүйлс нүүрсний зах зээлийн төлөв байдлыг улам бүр тодорхой бус болгож байна. Цаашид нүүрсний зах зээлийн төлөв сайжрахгүй гэж олон улсын шинжээчид дүгнэж байна (Зураг 7).

Зураг 7. Нүүрсний үнийн динамик



Эх сурвалж: ОУВС, Рио Тинто, 2015/9 сар, Дэлхийн Түүхий Эдийн Зах Зээлийн Тойм 2015/10 сар, UBS Metal Insight

Үйлдвэрлэлийн бүтээгдэхүүний суурь орц болох түүхий газрын тосны зах зээлийн үнэ баррель тутамдаа 65 ам.доллараар унаж, 2015 оны 10-р сарын байдлаар 46 ам. доллартай тэнцэж буй нь 2013 онтой харьцуулахад 61 хувиар унасан үзүүлэлт юм.

Нөгөө талаас газрын гүн дэх занарыг хямд өртгөөр ашиглах шинэ технологийн нөлөөгөөр газрын тосны гол хэрэглэгч АНУ занарт түшиглэсэн хэрэглээг урамшуулах болж газрын тосны үнэ улам унах нөхцөл байдал үүссэн. ОУВС-ийн зүгээс түүхий газрын тосны үнэ олборлох өртөгтэйгөө тэнцсэн тул ирэх жилүүдэд бага зэрэг өсөлттэй байхаар таамаглаж байна (Зураг 8).

Газрын тосны үнэ цаашид уналттай чигээр хадгалагдвал нүүрсний зах зээлийн уналт улам даамжирч эрчим хүч, дулаан, цахилгаан үүсгэх нүүрсний төслүүд зогсонги байдалд орох болно.


Зураг 8. Түүхий газрын тосны үнийн динамик



Эх сурвалж: ОУВС, Рио Тинто, 2015/9 сар, Дэлхийн Түүхий Эдийн Зах Зээлийн Тойм 2015/10 сар, UBS Metal Insight

БНХАУ-ын аж үйлдвэрлэлийн сааралт дэлхийн төмрийн хүдрийн зах зээлд хүндхэн цохилт болсоор байгаа ба дэлхийн зах зээл дэх төмрийн хүдрийн үнийн уналт цаашид үргэлжилнэ гэж ОУВС-аас таамаглаж байна (Зураг 9).

Зураг 9. БНХАУ-ын импортолж буй төмрийн хүдрийн үнийн динамик




Эх сурвалж: ОУВС, Рио Тинто, 2015/9 сар, Дэлхийн Түүхий Эдийн Зах Зээлийн Тойм 2015/10 сар, UBS Metal Insight

Боловсруулалт, олборлох зардал, тээвэрлэлийн өртгийг бууруулсан улс орнууд экспортын өрсөлдөөнд давамгайлна.

Дэлхийн нүүрсний зах зээлийн төвлөрөл нь сүүлийн 10 жилд Номхон далайн бүс ялангуяа БНХАУ-д төвлөрсөн хэлбэрт шилжсэн бөгөөд дараагийн 10 жилд ч энэ нөхцөл байдал хэвээр хадгалагдах төлөвтэй байна (Зураг 10). Ази тивийн нийт импортоор авч буй нүүрс нь Европ тивээс даруй гурав дахин их байгаа нь Азийн зах зээлд төвлөрөл хурдтай нэмэгдэж байгааг илэрхийлж байна.

Нүүрсний экспортыг нэмэгдүүлэх чиглэлд улс орнууд хөрөнгө оруулалтыг ихээр хийх болсон. 2019 он гэхэд 270 сая тонн нүүрсийг нэмж тээвэрлэх боломж бүхий дэд бүтцийг шинээр барихаар нүүрс экспортлогч орнууд ажиллаж байна. Австрали улс нүүрсний салбарын дэд бүтцээ өргөтгөж 2019 онд хүчин чадлаа 32 сая тонноор нэмэгдүүлэхэд 5 тэрбум ам.долларын хөрөнгө оруулалт хийхээр төлөвлөсөн байна.

Зураг 10. Олон улсын нүүрсний өрсөлдөөн



Эх сурвалж: Wood Mackenzie, Дэлхийн Нүүрсний зах зээлийн 2020 хүртэлх төлөв байдлын тайлан, Голден Трайнгле тайлан, Судалгааны багийн дүн шинжилгээ

Нөхцөл байдлаас дүгнэхэд зах зээлийн өрсөлдөөн улам бүр гүнзгийрч, боловсруулалт, олборлох зардал, тээвэрлэлийн өртгийг бууруулсан улс орнууд нүүрс экспортын өрсөлдөөнд давамгайлах нөхцөл бүрдэж байна. Нөгөө талаас газрын тосны үнийн уналт нь нүүрсний зах зээлд сөрөг нөлөө үзүүлсэн хэвээр байх хандлагатай байна.

ГУРАВ. 2016 ОНЫ НЭГДСЭН ТӨСВИЙН ТАНИЛЦУУЛГА

2016 оны Нэгдсэн төсвийн нийт тэнцвэржүүлсэн орлогыг 6.98 их наяд төгрөг буюу 2015 оны тодотгол 2-оос 15.1%-иар, зардлыг 7.88 их наяд төгрөг буюу 14.9% -иар тус тус нэмэгдүүлэн төсөвлөсөн (Зураг 11). Төсвийн алдагдлыг Нэрлэсэн ДНБ-ий 3.27% буюу 0.9 их наяд төгрөгт тооцсон.


Нэрлэсэн ДНБ-ийг 27.58 их наяд төгрөгт хүрч 2015 оны тодотголоос 17.1%-иар өсөхөөр төсөөлсөн. Төсвийн тогтворжуулалтын санд 8.45 тэрбум төгрөг хуримтлуулахаар төлөвлөсөн.

Нийт төсвийн орлогын 79% буюу 5.52 их наяд төгрөгийг татварын орлогоос, 16% буюу 1.08 их наяд төгрөгийг татварын бус орлогоос, 5% буюу 0.36 их наяд төгрөгийг тусламжийн орлогоос тус тус бүрдүүлэхээр тооцсон.

Нийт зардлын 77% буюу 6.06 их наяд төгрөгийг урсгал зардалд, 25.6% буюу 2.01 их наяд төгрөгийг хөрөнгийн зардалд тус тус зарцуулахаар тооцсон.


2011 оноос хойш буюу сүүлийн 5 жилд төсвийн нийт хуримтлагдсан алдагдал 4.2 их наяд төгрөгт хүрч төсвийн алдагдлыг цаашид санхүүжүүлэхэд төвөгтэй, эх үүсвэр улам бүр өндөр зардалтай болсоор байна. 2016 оны хувьд 0.9 их наяд төгрөгийн алдагдалтай байхаар тооцож буй нь нөхцөл байдлыг улам бүр хүндрүүлэхээр байна (Зураг 12).

Зураг 11. 2016 оны нэгдсэн төсвийн орлого ба зардал



Эх сурвалж: Монгол Улсын Сангийн яам, Монголбанк, Судалгааны багийн дүн шинжилгээ


Зураг 12. 2016 оны нэгдсэн төсвийн тэнцэл



Эх сурвалж: Монгол Улсын Сангийн яам, Монголбанк, Судалгааны багийн дүн шинжилгээ

2016 оны нэгдсэн төсвийн төслийг 2015 оны батлагдсан төсвөөс бууруулсан ч 2015 оны тодотгол 2 –оос өсөхөөр буюу өөдрөг тооцсон (Зураг 13).


Зураг 13. 2015 ба 2016 оны нэгдсэн төсвийн харьцуулалт



Эх сурвалж: Монгол Улсын Сангийн яам, Монголбанк, Судалгааны багийн дүн шинжилгээ

Түүхий эдийн үнэ ба Монгол Улсын төсвийн төлөвлөлт хоорондын хамаарлыг авч үзвэл 2004-2012 онд түүхий эдийн үнэ ба төсвийн орлогын хооронд хүчтэй хамаарал ажиглагдаж байв. Эдгээр онд зэс ба нүүрсний экспортын өсөлтөөс хамааруулан төсвийн их хэмжээний тэлэлтийг бий болгосон. 2012 оноос хойш уг хамаарал харьцангуй багассан бөгөөд дэлхийн зах зээл дээр түүхий эдийн үнэ унасан ч Чингис бондоор дамжуулан төсвийн тэлэлтийг үргэлжлүүлсэн (Зураг 14).


Зураг 14. Түүхий эдийн үнийн цикл ба Монгол улсын төсвийн төлөвлөлт



Эх сурвалж: Монгол Улсын Сангийн яам, Монголбанк, Судалгааны багийн дүн шинжилгээ

2006 оноос хойших Монгол Улсын төсвийн төлөвлөлтийн ерөнхий дүр зургийг судалгааны багийн зүгээс тодорхойлохыг оролдов (Зураг 15). 2006-2010 онд түүхий эдийн үнийн огцом өсөлт, хөрөнгө оруулалтын идэвх нэмэгдсэнээс шалтгаалан төсвийн нэмэлт орлого бий болж, төсвийн тэнцэл илүүдэлтэй гарсан. Энэ үед сонгуулийн амлалтууд ба нийгмийн халамжийн хөтөлбөрүүд нь төсвийн зарлагын тэлэлтийг бий болгосон. 2011-2016 онд түүхий эдийн үнийн уналт, гадаадын хөрөнгө оруулалтын бууралт, төгрөгийн ханшийн уналт зэрэг хүчин зүйлсээс шалтгаалан төсвийн орлогын тасалдал бий болсон бөгөөд төсвийн алдагдлыг санхүүжүүлэх зорилгоор Засгийн газрын гадаад ба дотоод үнэт цаасыг их хэмжээгээр гаргаж, өрийн дарамт нэмэгдсэн. Цаашид 2017-2022 онд олон улсын эдийн засгийн тодорхой бус байдал, Монгол Улсын эдийн засгийн төлөв, гадаад бондуудын эргэн төлөлт зэргээс шалтгаалан төсвийн эмзэг байдал үргэлжлэх төлөвтэй байна.

Зураг 15. Монгол улсын төсвийн төлөвлөлт



Эх сурвалж: Татварын шинжээч Б.Батжаргал, ОУВС тайлан, Монголын эдийн засгийн талаарх судалгаанууд, Багийн дүн шинжилгээ

ДӨРӨВ. 2016 ОНЫ НЭГДСЭН ТӨСВИЙН ОРЛОГЫН ШИНЖИЛГЭЭ

2016 онд эдийн засгийн идэвх сэргэх таамаглалд суурилан төсвийн голлох татваруудын өсөлтийг тооцсон.


Орлогын албан татвар: Төслөөр 2016 онд 1.1 их наяд төгрөгт хүрч тодотгол 2-той харьцуулахад 86.7 тэрбум төгрөгөөр буюу 8.5%-иар өсөхөөр төлөвлөсөн. Эдийн засгийн ил тод байдлыг дэмжих тухай хууль хэрэгжсэнээр ААНОАТ нэмэгдэж 0.56 их наяд төгрөгт хүрч, тодотгол 2-оос 9%-иар буюу 45.6 тэрбум төгрөгөөр нэмэгдэнэ гэж тооцсон.

Эдийн засгийн идэвхтэй холбоотой татварууд: НӨАТ-ын орлогын төсөөлөл нь тодотгол 2-той харьцуулахад 16%-иар буюу 195 тэрбум төгрөгөөр өсөхөөр байна. НӨАТ-ын орлогын 60 гаруй хувийг импортын бараанаас төвлөрүүлдэг. Эдийн засгийн идэвх буурч байгаа нөхцөлд НӨАТ-ын орлогыг хэт өөдрөг таамагласан байх магадлалтай. Төсөлд Оюу Толгой болон Таван Толгой төслийн бүтээн байгуулалтыг хэрэгжинэ гэж төлөвлөн гадаад худалдаа, хөрөнгө оруулалтын идэвхтэй холбоотой татваруудын хувь хэмжээг өсгөхөөр төлөвлөсөн нь сонгуулийн жилтэй давхцаж буй нь анхаарал татаж байна.

Бусад төлбөр хураамж: 2016 оны төсөлд 0.65 их наяд төгрөгт хүрч тодотгол 2-оос 15%-иар буюу 113 тэрбум төгрөгөөр буурахаар тооцсон. Тус бууралтын шалтгаан нь өсөн нэмэгдэх роялтигаас орлого төвлөрөх боломжгүй болсонтой холбоотой. Мөн шинээр нийслэл Улаанбаатар хотын албан татварт 20 тэрбум төгрөг төвлөрөхөөр тооцсон.

Татварын бус орлогууд: 2016 оны төсөлд 1.08 их наяд төгрөгт хүрч, тодотгол 2-той харьцуулахад 167.4 тэрбум төгрөгөөр буюу 18.2%-иар өсөхөөр төлөвлөсөн.

Зураг 16. 2016 оны нэгдсэн төсвийн урсгал орлогын бүтэц



Эх сурвалж: Nichert шинжилгээ, Монгол улсын Сангийн яам, Судалгааны багийн дүн шинжилгээ


Уул уурхайн салбарын орлогын төлөвлөлт илүү бодитой болсоор байна. Гэвч эрсдэлийг сайн тооцох хэрэгтэй.

Сүүлийн 5 жилд дунджаар уул уурхайн салбараас жил бүр 1.04 их наяд төгрөгийг төсөвт төвлөрүүлсэн бөгөөд энэ нь нийт татварын орлогын 20%-ийг буюу татварт хураасан 5 төгрөг тутмын 1 төгрөг нь уул уурхайн татвараас бүрдэж байсан (Зураг 17). 2016 оны хувьд уул уурхайн салбараас 0.9 их наяд төгрөгийг төвлөрүүлэхээр тооцсон.

Татварын орлого төрөлжөөгүйн улмаас орлогыг зохиомлоор өсгөх, зардалтай нийцүүлэх орон зайг уул уурхайн татварын орлого бий болгодог дутагдал өмнөх онуудын төсөвт нийтлэг ажиглагддаг байсантай харьцуулахад 2016 оны төлөвлөлт харьцангуй дэвшилттэй, бодит болсон.

2015 оны эхний 3-н улирлын уул уурхайн салбарын гүйцэтгэлээс харахад зэсийн баяжмалаас бусад бүх төрлийн түүхий эдийн экспорт 11 улирал дараалан буурсан дүнтэй байна. Энэ нь уул уурхайн суперцикл дуусч, БНХАУ-ын хурдтай өсөлт саарсан, боловсруулаагүй түүхий эдийн эрэлт буурсан зэрэг олон суурь шалтгаануудтай.


Зураг 17. Уул уурхайн салбарын орлогоос хамаарах хамаарал



Эх сурвалж: Сангийн яам, Судалгааны багийн дүн шинжилгээ

Татварын төрлүүдээр авч үзсэн орлогын хувьд АМНАТ-аас нийт орлогын 45% буюу 405 тэрбум төгрөг, ААНОАТ-аас 14% буюу 128 тэрбум төгрөг, ноогдол ашгийн орлогоос 4% буюу 39 тэрбум төгрөг төвлөрүүлэхээр тус тус төлөвлөсөн (Зураг 18). Харин өсөн нэмэгдэх АМНАТ-аас төсөвт ямар нэгэн орлого төвлөрөхгүй байхаар тооцсон нь 2016 онд экспортын түүхий эдийн үнийн өсөлт хуульд заасан босго түвшнээс бага байгаатай холбоотой.

Зураг 18. Уул уурхайн татварууд (голлох татварын төрлүүдээр)




Эх сурвалж: Сангийн яам, Судалгааны багийн дүн шинжилгээ

2016 оны төсөлд нийт 23.6 тонн алт (үүний 10.1 тонныг Оюу Толгойгоос)-ыг олборлож, төсөвт 173 тэрбум төгрөгийг төвлөрүүлэхээр тооцсон. Үнийн хувьд өмнөх жилээс 0.5%-иар нэмж, унц нь 1156 ам. доллар байхаар төсөөлсөн. Тоо хэмжээний хувьд өмнөх жилээс 25%-иар бууруулан тооцсон хэдий ч 2015 оны хүлээгдэж буй гүйэтлгэлтэй харьцуулахад 5.6 тонноор буюу 31%-иар өсөхөөр тооцсон. Энэхүү төсөлд тусгасан дүнгээр олборлож чадвал Монгол Улс дэлхийн топ 20 алт олборлогч орны нэг болох боломжтой.

Нүүрсний салбараас 19.5 сая тонн нүүрс экспортлохоор төлөвлөж, төсөвт 271 тэрбум төгрөгийг төвлөрүүлэхээр тооцсон. Үнийн хувьд өмнөх жилээс 46%-иар бууруулж дунджаар тонныг 43.8 ам.доллар байхаар тооцсон нь Гашуут Сухайтын EXW³-аас 12 ам.доллараар өндөр байна. Тоо хэмжээний хувьд өмнөх жилээс 2.5%-иар бууруулан тооцсон ч 2015 оны хүлээгдэж буй гүйцэтгэлтэй харьцуулахад 6 сая тонноор буюу 44.4%-иар өсөхөөр тооцсон.

23–28 хувийн агууламжтай зэсийн 1.36 сая тонн баяжмал (үүний 0.587 сая тонныг Эрдэнэтээс)-ыг экспортлож 373 тэрбум төгрөгийн татвар хураахаар төлөвлөсөн. Үнийн хувьд эрдэс баялгийн бүтээгдэхүүний үнийг шинэчилсэн аргачлалаар тооцож тонн нь 5,137.7 ам.доллар байхаар төсөлд тусгасан (Зураг 19).

Зураг 19. Уул уурхайн салбарын орлогын төлөвлөлт



Эх сурвалж: Сангийн яам, Судалгааны багийн дүн шинжилгээ

³ Бараа нийлүүлэх нөхцлийн код: Үйлдвэрээс, агуулахаас ачих (нэр заасан газар)

ТАВ. 2016 ОНЫ НЭГДСЭН ТӨСВИЙН ЗАРЛАГЫН ШИНЖИЛГЭЭ


Нэгдсэн төсвийн нийт зарлага 2015 оны 3-р улирлын байдлаар жилийн төлөвлөгөөтэй харьцуулахад 62.7 хувийн гүйцэтгэлтэй байна.

2015 оны 3-р улирлын байдлаар нэгдсэн төсвийн нийт зарлага жилийн төлөвлөгөөтэй харьцуулахад 62.7 хувийн гүйцэтгэлтэй байна. Зардлын төрөл тус бүрээр авч үзвэл цалин хөлс, НДШ-ийн зардал 68.6%, бараа үйлчилгээний бусад зардал 65.6%, хүүгийн зардал 57.1%, татаас 101.0%, урсгал шилжүүлэг 73.6%-ийн гүйцэтгэлтэй буюу нийт урсгал зардлын гүйцэтгэл 69.2% байгаа бол хөрөнгийн зардлын гүйцэтгэл 42.7% байна.

Нийт зарлага ба цэвэр зээлийн ДНБ-д эзлэх хувь буурна гэж төлөвлөсөн.

Монгол улсын 2016 оны нэгдсэн төсвийн нийт зарлага ба цэвэр зээлийн дүнг 7.88 их наяд төгрөгөөр төсөвлөсөн бөгөөд өмнөх оны тодотгол 2-оос 575.8 тэрбум төгрөгөөр буюу 7.88%-иар өссөн байна. 2016 оны нэгдсэн төсвийн нийт зарлага ба цэвэр зээлийн ДНБ-д эзлэх хувь өмнөх онуудтай харьцуулахад буурч 28.6% -тай тэнцүү байхаар төсөвлөжээ (Зураг 20). Нийт зарлагын 76.9% буюу 6.06 их наяд төгрөгийг урсгал зардалд, 25.5% буюу 2.01 их наяд төгрөгийг хөрөнгийн зардалд төсөвлөсөн.

Зураг 20. Нэгдсэн төсвийн нийт зарлага ба цэвэр зээл



Цалин хөлс, НДШ-ийн зардал буурч, зээлийн үйлчилгээний төлбөр ба татаасын хэмжээ өснө.


2016 оны нэгдсэн төсвийн нийт урсгал зарлагыг 6.07 их наяд төгрөгөөр төсөвлөсөн бөгөөд энэ нь өмнөх оны тодотгол 2-оос 286.5 тэрбум төгрөгөөр буюу 4.9%-ийн өсөлттэй байна. Урсгал зарлагын нийт зарлагад эзлэх хувь 76.9% байна.

Урсгал зарлагыг зардлын төрөл тус бүрээр авч үзвэл өмнөх оны тодотголтой харьцуулахад цалин хөлс 10.0%-иар буурч, бараа үйлчилгээний зардал 16.3%, зээлийн үйлчилгээний төлбөр 31.4%, татаас 53.3%, урсгал шилжүүлэг 0.09%-иар тус тус өсчээ (Зураг 21).

Нийт урсгал зарлага дахь зээлийн үйлчилгээний төлбөрийн хувийн жин өссөн бөгөөд 2016 онд нийт урсгал зарлагын 15.9%-ийг зээлийн үйлчилгээний төлбөрт зарцуулахаар байна. Нийт урсгал зардлын өсөлтөд зээлийн үйлчилгээний төлбөрийн өсөлт голлон нөлөөлжээ.

Засгийн газар, засгийн газрын агентлагууд, төсвийн бусад байгууллагуудад бүтцийн өөрчлөлт хийх, цомхотгох, төрийн захиргааны албан хаагчдийн цалинг бууруулах замаар урсгал зарлагыг бууруулах бодлого баримтлахаар төлөвлөжээ.

Зураг 21. 2016 оны нэгдсэн төсвийн урсгал зарлага




Эх сурвалж: Сангийн яам, Судалгааны багийн дүн шинжилгээ

Бүтцийн өөрчлөлт хийх замаар төрийн албан хаагчдын тоог цөөрүүлж, урсгал зардлыг бууруулахаар төлөвлөсөн.

2016.08.01-нээс эхлэн одоогийн Аж үйлдвэрийн яам, Хүнс, хөдөө аж ахуйн яамд нэгдэн Хөдөө аж ахуйн яам нэртэйгээр, Эрүүл мэндийн яам, Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын яам, Хөдөлмөрийн яамд нэгдэн Эрүүл, мэнд нийгмийн хамгааллын яам нэртэйгээр, Барилга, хот байгуулалтын яам, Зам тээврийн яам, Уул уурхайн яам, Эрчим хүчний яамд нэгсэн Дэд бүтцийн яам нэртэйгээр тус тус шинээр зохион байгуулалтад орж ажиллах, тэдгээрийн харьяа агентлаг, төсөвт байгууллагуудыг нэгтгэх, татан буулгах замаар бүтцийн өөрчлөлт хийхээр төлөвлөсөн. Бүтцийн өөрчлөлт хийснээр төрийн албан хаагчдын тоог 3054-өөр цөөрүүлж, урсгал зардлыг 50.3 тэрбум төгрөгөөр бууруулахаар төлөвлөсөн (Зураг 22).

Зураг 22. Бүтцийн өөрчлөлтийн дүнд буурах орон тоо, урсгал зардал




Эх сурвалж: Сангийн яам, Судалгааны багийн дүн шинжилгээ

Зээлийн үйлчилгээний төлбөрийн хэмжээ өмнөх онуудтай харьцуулахад эрс өссөн.

Зээлийн үйлчилгээний төлбөр эрс өсч 2010 онтой харьцуулахад 22.7 дахин нэмэгдсэн байна (Зураг 23). 2016 оны төсөлд нийт зээлийн үйлчилгээний төлбөрийн 29.2 хувь нь гадаад зээлийн үйлчилгээний төлбөр, 70.8 хувь нь дотоод зээлийн үйлчилгээний төлбөр байна.


Зураг 23. Зээлийн үйлчилгээний төлбөр



Эх сурвалж: Сангийн яам, Судалгааны багийн дүн шинжилгээ

2014 онд засгийн газрын дотоод үнэт цаасны хүү өссөн ба энэ өсөлт нь зээлийн үйлчилгээний төлбөрийг нэмэгдүүлэх, түүнчлэн арилжааны банкуудын хувийн хэвшилд олгох зээлийн хэмжээг бууруулахад нөлөөлсөн (Зураг 24). Харин 2015 он 6-р сард олон улсын зах зээл дээр 1.0 тэрбум юантай тэнцэх Дим сам бондыг гаргаж, Засгийн газрын дотоод үнэт цаасны хэмжээг бууруулсан бөгөөд үр дүнд нь Засгийн газрын дотоод үнэт цаасны хүүний түвшин буурч эхлээд байна.

Зураг 24. Засгийн газрын 28 долоо хоногийн хугацаатай үнэт цаасны хүү




Эх сурвалж: Сангийн яам, Судалгааны багийн дүн шинжилгээ

Барилга байгууламж, тоног төхөөрөмжийн зардал өсч, стратегийн нөөц хөрөнгийн хэмжээ буурна.

2016 оны нэгдсэн төсвийн нийт хөрөнгийн зардлыг 2.02 их наяд төгрөгөөр төсөвлөсөн бөгөөд энэ нь өмнөх оны тодотгол 2-оос 437.7 тэрбум төгрөгөөр буюу 27.7%-иар өсчээ. Хөрөнгийн зардлын нийт зарлагад эзлэх хувийн жин 25.5% байна.

Хөрөнгийн зардлыг төрөл тус бүрээр нь авч үзвэл өмнөх оны тодотгол 2-той харьцуулахад барилга байгууламжийн зардал 64.5%, их засварын зардал 1.9%, тоног төхөөрөмжийн зардал 153.7%, төсвөөс эргэн төлөгдөх хөрөнгө оруулалт 1.2%-иар өсч, стратегийн нөөц хөрөнгө 43.3%-иар буурчээ (Зураг 25). 2015 оноос Хөгжлийн банкнаас санхүүжих хөрөнгө оруулалтын төслүүдийг нэгдсэн төсвийн бүрэлдэхүүнд оруулж тооцох болсон. 2016 онд Хөгжлийн банкны эх үүсвэрээр төсвөөс эргэн төлөгдөх нөхцөлтэй хөрөнгө оруулалтын хэмжээг 450 тэрбум төгрөгөөр төсөвлөсөн.

Зураг 25. 2016 оны нэгдсэн төсвийн хөрөнгийн зардал




Эх сурвалж: Сангийн яам, Судалгааны багийн дүн шинжилгээ

Сүүлийн жилүүдэд хөрөнгө оруулалтын хэмжээ тасралтгүй буурч байна.

2016 онд нийт 893.5 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт төсөвлөсөн бөгөөд энэ нь 2015 оны хүлээгдэж буй гүйцэтгэлтэй харьцуулахад 24.5%-иар бага үзүүлэлт юм. Нийт хөрөнгө оруулалтын 50.3% буюу 446.5 тэрбум төгрөгийг улсын төсвөөс, 49.7% буюу 450.0 тэрбум төгрөгийг төсвөөс эргэн төлөгдөх нөхцөлтэйгээр Хөгжлийн банкны эх үүсвэрээс санхүүжүүлэхээр төсөвлөсөн (Зураг 26).


Зураг 26. Улсын төсөв болон Хөгжлийн банкны эх үүсвэрээр хийгдэж буй хөрөнгө оруулалтын хэмжээ



Эх сурвалж: Сангийн яам, Судалгааны багийн дүн шинжилгээ

2016 онд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар нийт 562 төсөл, арга хэмжээг 443.5 тэрбум төгрөгөөр санхүүжүүлэхээр төлөвлөсөн (Зураг 27). Улсын төсвийн хөрөнгө оруулалтын 71.4% буюу 316.5 тэрбум төгрөгийн 450 төсөл, арга хэмжээ нь өмнөх онуудад эхэлсэн, он дамжин хэрэгжиж байгаа төслүүд байна. Улсын төсвийн хөрөнгө оруулалтын 28.6% хувь буюу 127.0 тэрбум төгрөгийн 112 төсөл, арга хэмжээ нь 2016 онд шинээр хэрэгжиж эхэлнэ. Улсын төсвийн хөрөнгө оруулалтын 50% нь боловсрол, соёл, эрүүл мэндийн салбарт хийгдэхээр байна.


Зураг 27. Улсын төсвөөс санхүүжих хөрөнгө оруулалт (салбараар)



Эх сурвалж: Сангийн яам, Судалгааны багийн дүн шинжилгээ

2015 оноос Хөгжлийн банкнаас санхүүжих хөрөнгө оруулалтыг нэгдсэн төсвийн бүрэлдэхүүнд оруулж тооцох болсон. 2015 оны тодотгосон төсөвт Хөгжлийн банкны эх үүсвэрээр төсвөөс эргэн төлөгдөх нөхцөлтэй 444.6 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт тусгагдсан бол 2016 онд өмнөх оноос 1.2%-иар их буюу 450.0 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт тусгагдсан (Зураг 28).


Зураг 28. Улсын төсвөөс эргэн төлөгдөх нөхцөлтэй Хөгжлийн банкны эх үүсвэрээс санхүүжих хөрөнгө оруулалт (салбараар)



Эх сурвалж: Сангийн яам, Судалгааны багийн дүн шинжилгээ

Урсгал зардал ба хөрөнгийн зардлын хуваарилалтыг төсвийн ерөнхийлөн захирагчдаар авч үзвэл нийт урсгал зардлын 29%-ийг Сангийн сайд, 21%-ийг Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайд, 12%-ийг Эрүүл мэнд, спортын сайд, 10%-ийг Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын сайд, 50%-ийг бусад сайд нар захиран зарцуулна. Нийт хөрөнгийн зардлын 29%-ийг Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайд, 16%-ийг Сангийн сайд, 14%-ийг Зам тээврийн сайд, 12%-ийг Эрүүл, мэнд, спортын сайд, 30%-ийг бусад сайд нар захиран зарцуулна (Зураг 29).

**Зураг 29. Урсгал зардал ба хөрөнгийн зардлын хуваарилалт
(Төсвийн ерөнхийлөн захирагчдаар)**



Эх сурвалж: Сангийн яам, Судалгааны багийн дүн шинжилгээ

ОУВС-ийн статистик мэдээллээс харахад дэлхийн ихэнх улс орны засгийн газрын нийт зарлагын ДНБ-д эзлэх хувийн жин 2016 оноос буурна гэж тооцоолжээ. Монгол улсын хувьд засгийн газрын нийт зарлагын ДНБ-д эзлэх хувийн жин цаашид буурч, дэлхийн дунджаас бага түвшинд очно гэж таамагласан байна (Хүснэгт 1).

Хүснэгт 1. Дэлхийн улс орнуудын засгийн газрын нийт зарлагын ДНБ-д эзлэх хувийн харьцуулалт

нгилал	2010	2011	2012	2013	2014	2015	2016	2017	2018	2019	2020
Дэлхийн дундаж	35.4	34.8	35.0	35.3	35.3	35.3	34.7	34.2	33.9	33.5	33.4
Хөгжингүй эдийн засаг	42.3	41.6	40.9	40.5	40.1	39.5	39.0	38.4	38.1	38.0	38.0
Европын бүс нутаг	50.4	48.9	49.5	49.3	49.0	48.3	47.6	47.1	46.7	46.3	46.0
Голлох хөгжингүй орнууд(G7)	42.9	42.2	41.4	41.0	40.6	40.0	39.6	39.0	38.7	38.7	38.8
Бусад хөгжингүй орнууд (G7 ба европын бүс нутгийг оруулахгүй)	33.3	33.3	33.3	33.3	32.8	32.4	31.8	31.4	31.2	30.9	30.7
Европын холбоо	49.3	47.9	48.3	47.8	47.6	46.7	45.9	45.2	44.7	44.3	44.0
Хөгжиж буй улс орнууд	29.7	29.4	30.1	30.8	31.1	31.4	30.9	30.5	30.1	29.7	29.4
Хөгжиж буй Ази	25.0	25.4	26.8	27.6	27.9	28.7	28.6	28.3	28.2	27.8	27.5
Хөгжиж буй Европ	40.9	39.6	39.5	40.1	39.8	39.2	38.8	38.7	38.6	38.7	38.8
ASEAN-5	20.6	20.5	21.9	22.0	21.5	20.8	21.1	21.0	21.1	21.1	21.0
Латин Америк, Карибын тэнгис	32.3	32.5	32.8	33.2	34.3	34.4	34.1	33.4	32.9	32.7	32.7
Ойрхи дорнод, Хойд Африк, Афганистан, Пакистан	31.1	30.3	30.3	32.7	34.1	37.1	35.4	34.2	33.3	32.2	31.5
Саб-Сахарын Африк	25.0	25.2	24.4	23.9	23.6	22.8	22.4	22.4	22.4	22.1	22.1
Монгол*	31.6	37.9	38.9	40.1	38.8	33.8	32.2	31.0	30.0	29.0	29.3

ЗУРГАА. МАКРО ЭДИЙН ЗАСГИЙН ТЭНЦВЭР БА НЭГДСЭН ТӨСӨВ


Төсвийн хяналт суларсны улмаас жил бүр тодотгодог сахилга батгүй төсвийн бодлоготой болсон.

2016 оны Нэгдсэн төсвийн нийт алдагдлыг нэрлэсэн ДНБ-ий 3.27% буюу 0.901 их наяд төгрөгт тооцсон нь тодотгол 2-той харьцуулахад 24%-иар буурсан (Зураг 30). Нэрлэсэн ДНБ-ийг 27.58 их наяд төгрөгт хүрч 2015 оны тодотголоос 17.1%-иар өсөхөөр төсөөлсөн.

Жил бүрийн төсвийг тодотгон өөрчлөх буруу жишиг сүүлийн 10 гаруй жил бий болсон нь төсвийн сахилга батыг улам бүр сулруулж байна. 2010-2015 оны хооронд төсвийн алдагдал Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан хувь хэмжээнд гүйцэтгэлээр хүрсэн нь зөвхөн 2013 он юм. 2015 оны хувьд 2 удаа тодотгосон, мөн Төсвийн тогтвортой байдлын хуулийг шинэчлэн найруулж төсвийн нийт алдагдлыг ДНБ-ий 5%-д хүргэсэн.

2012 оноос эхлэн Хөгжлийн банкны төсвийн гадуурх санхүүжилтийг нэгдсэн төсвөөс тусдаа тооцож байсан нь төсвийн сахилга бат сулрах нэг шалтгаан болсон. 2015 оноос эхлэн төсвөөс эргэн төлөгдөх зардлуудыг төсөвт багтаадаг болсон. Мөн өмнөх жилүүдийн уул уурхайн баялагаас олсон их хэмжээний орлого нь төсвийн хяналтыг сулруулсан гол шалтгаан юм.

Зураг 30. Нэгдсэн төсвийн тэнцэл




Эх сурвалж: Сангийн яам, Судалгааны багийн дүн шинжилгээ

Төсөвт тавих хяналтыг эрс нэмэгдүүлэх, баталсан түвшнээс илүү алдагдал бий болгохыг зөвшөөрөхгүй байх, төсвийн зарцуулалтын үр ашиг, ил тод байдалд өндөр шаардлага тавих хэрэгтэй.

2012-2015 онд Засгийн газрын зүгээс УИХ-аар батлуулсан төсвийн алдагдлын хэмжээнээс даруй 2.1 их наядаар буюу 1.02 тэрбум долларыг хяналтгүй зарцуулсан байна. Өөрөөр хэлбэл, 2012 оноос хойш төсвийн алдагдлын нэрлэсэн тоо хэмжээг жил бүр өсгөн баталж, түүнээсээ илүү хэмжээний алдагдлыг хэтрүүлэн бий болгосон (Зураг 31).

Зураг 31. Нэгдсэн төсвийн алдагдал




Эх сурвалж: Сангийн яам, Судалгааны багийн дүн шинжилгээ

Их хэмжээгээр хэтэрсэн төсвийн алдагдлыг нөхөх зорилгоор дотоодын болон гадаадын бонд, засгийн газрын баталгааг жил дараалан гаргасан. Үүний улмаас Өрийн удирдлагын хуулийг шинэчлэн баталсан. Цаашид төсөвт тавих хяналтыг эрс нэмэгдүүлэх, баталсан түвшнээс илүү алдагдал бий болгохыг зөвшөөрөхгүй байх, төсвийн зарцуулалтын үр ашиг, ил тод байдлыг хангаж ажиллах хэрэгтэй байна. Баталсан түвшнээс төсвийн алдагдлыг хэтрүүлсэн тохиолдолд хариуцлага тооцдог бодит механизм бий болгох шаардлагатай.

Төсвийн он дараалсан алдагдлууд хувийн хэвшлийн өсөлтөд сөргөөр нөлөөлсөн.

Төсвийн хэт тэлэлт, хяналтгүй төсвийн алдагдал, түүнийг санхүүжүүлэх эх үүсвэр нь хувийн хэвшлийн өрсөлдөөнийг бууруулж, шахан гаргах үзэгдэл бий болгосон. 2014 оны 1-р улирлаас эхлэн арилжааны банкууд зүгээс актив хөрөнгөө Засгийн газрын болон Монголбанкны үнэт цаасанд байршуулан төсвийн алдагдлыг санхүүжүүлж улмаар хувийн секторын өсөлтийг хязгаарласан. Өөрөөр хэлбэл, Засгийн газрын хэт тэлэлт нь хувийн секторын өсөлтийг бууруулах гол хүчин зүйл болсон (Зураг 32).

Зураг 32. Мөнгөний нийлүүлэлт ба бизнесийн идэвх (Засгийн газрын шахан гаргах үзэгдэл)




Эх сурвалж: Сангийн яам, Монголбанк, Судалгааны багийн дүн шинжилгээ

Монголбанкинд мөнгөний бодлогын хүүг бууруулж, зээлийн өсөлтийг тэтгэн эдийн засгийн өсөлтийг урамшуулах бодлогын орон зай байхгүй.

2014 оны 3-р улирлаас хойш бодит ДНБ-ий өсөлт 4 улирал, уул уурхайн бус ДНБ-ий өсөлт 5 улирал тус тус дараалан буурсан. Хүнс болон улирлын нөлөө бүхий инфляцийг хасаж тооцдог суурь инфляцийн түвшин 2014 оны 2-р улирлаас хойш 6 улирал дараалан буурч 6.1% хувьд хүрсэн (Зураг 33).

Зураг 33. Бодит ДНБ ба суурь инфляцийн өсөлт



Эх сурвалж: Монголбанк, Судалгааны багийн дүн шинжилгээ

2015 оны 9-р сарын байдлаар Монголбанк нийт 11.5 их наяд төгрөгийн нийлүүлэлтийг хийсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 16%-иар өссөн үзүүлэлт юм. Мөнгөний нийлүүлэлт (M2)-ийн өсөлтийг дан ганц дотоод цэвэр активаар хангаж буй нь Монголбанкны гадаад валютын нөөц татарсантай шууд холбоотой (Зураг 34).

Цаашид гадаад валютын нөөц нэмэгдэхгүй тохиолдолд Монголбанк мөнгөний нийлүүлэлтийг нэмэх, 2009 оны 2-р улирлаас хойш хамгийн өндөр түвшиндээ хүрээд буй мөнгөний бодлогын хүүг бууруулан эдийн засгийн өсөлтийг урамшуулах бодлогын орон зай байхгүй байна.

Сонирхолтой нь 2013 оны 1-р улирлаас 2014 оны 1-р улирал хүртэл Гадаад цэвэр актив, Гадаад валютын албан нөөц (ГВАН)-ийн өөрчлөлт хамтдаа ижил чиглэлд буурч байсан ч 2014 оны 3-р улирлаас эхлэн ГВАН хурдтай өсч эхлэсэн байна (Зураг 34). Энэ нь гурван үндсэн шалтгаантай. Үүнд: Нэгдүгээрт, Монголбанкинд тушаах алтны хэмжээ өссөн, Хоёрдугаарт, Арилжааны болон Хөгжлийн банкны гадаад бондууд гаргасан, Гуравдугаарт, БНХАУ-ын Ардын банктай хийж буй Юаны своп.

Зураг 34. Мөнгөний нийлүүлэлт ба гадаад валютын нөөц



Эх сурвалж: Монголбанк, Судалгааны багийн дүн шинжилгээ


Монголбанк 1.77 тэрбум ам.доллартай тэнцэх хэмжээний юаны своп хийсний дийлэнх хэсгийг төгрөгийн ханшийг тогтворжуулахад зарцуулсан.

2008 оны 3-р улирлаас 2009 оны 1-р улирлын хооронд төгрөгийн ханшийн огцом сулралтын эсрэг Монголбанк валютын нөөцөөрөө тэмцсэн боловч 500 орчим сая ам.долларыг ханш тогтворжуулахад зарцуулсан. Харамсалтай нь төгрөгийн ханш 1 улирлын дотор 27%-иар огцом суларсан. 2009 оны 3-р улиралд ОУВС болон донор байгууллагуудын зүгээс нийт 300 орчим сая долларын валютын тусламж авсан.

2012 оны 1-р улиралд анхны юаны своп хийж 71 сая ам.доллартай тэнцэх валютыг солилцсон бол 2015 оны 2-р улирлын байдлаар нийт 1.77 тэрбум ам.доллартай тэнцэх хэмжээний своп хийсэн нь төгрөгийн ам.доллартай харьцах ханшийг хүчээр барьж байгаа гол эх үүсвэр юм. Энэ нь анхны своп хэлцэлтэй харьцуулахад 24 дахин өссөн үзүүлэлт юм (Зураг 35).

2012 оны 2-р улиралд Монгол Улсын ГВАН 2.9 тэрбум, ам.доллартай харьцах төгрөгийн ханш 1328 байсан бол 2015 оны 2-р улирлын байдлаар ГВАН 1.3 тэрбум, ам.доллартай харьцах төгрөгийн ханш 1903 болсон. Энэ хугацаанд валютын дотогшлох урсгал татарсны улмаас төгрөгийн ханш суларч эхлэсэн тул Монголбанк юаны своп хэлэлцээрээр авсан гадаад валютаа ихэнхийг нь төгрөгийн ханшийг тогтвортой байлгахад зарцуулсан нь тодорхой юм. Тухайлбал, 2013 болон 2014 оны 3-р улирлуудад тус бүр 410 сая болон 395 сая ам.доллартай тэнцэх их хэмжээний своп хэлцэл хийсэн нь эдийн засгийн идэвх оргил түвшинд хүрч гадаад валютын хэрэгцээ идэвхждэг улирлын үед төгрөгийн ханшийг хүчээр тогтворжуулахад зарцуулсныг харуулж байна.

Зураг 35. Монгол банкны гадаад өр



Эх сурвалж: Монголбанк, Судалгааны багийн дүн шинжилгээ

^2011 оны 5-р сарын 6-ны өдөр Хятадын Ардын банктай төгрөг юан солилцох 10 тэрбум (ойролцоогоор 1.5 тэрбум ам.доллартай тэнцэх) юантай своп гэрээ байгуулж 2014 оны 8-р сарын 21-нд 15 тэрбум юан (ойролцоогоор 2.5 тэрбум ам.доллартай тэнцэх) болгон сунгасан.

Төгрөгийн ханш бусад түүхий эдийн валюттай⁴ харьцуулахад харьцангуй удаан, аажим суларсан.


Гадаад валюттай харьцах ханшийг гэнэтийн савалгаа, зах зээлийн бус шокоос сэргийлэх зорилгоор валютын захад оролцох бодлогыг ихэнх орны төв банкууд явуулдаг. Гэхдээ валютын захад төв банкнаас байнга оролцох нь ханшийн хүлээлтэд сөрөг нөлөө үзүүлдэг тул энэхүү бодлогыг тун болгоомжтой ашигладаг.

2011 оноос эхлэн Евро бүсийн өрийн хямрал, БНХАУ-ын эдийн засгийн удаашрал, АНУ QE Бондын худалдан авалт хөтөлбөр зогссон зэрэг хүчин зүйлсээс шалтгаалан олон улсад түүхий эдийн үнэ ханш буурсантай холбогдуулан түүхий эдийн валюттай орнуудын ханш ам.долларын эсрэг огцом сулрах болсон.

Эдгээр гадаад шок төгрөгийн ханшийг сулрах гадаад суурь шалтгаан болсон. Мөн ГШХО-ын бууралт, дотоод зээлийн тэлэлт, үнэ тогтворжуулах хөтөлбөр, ЗГ-ын бондын арилжаа зэрэг хүчин зүйлс төгрөгийн ханш сулрах үндсэн нөхцөл болсон.

Бусад түүхий эдийн валюттай харьцуулахад төгрөгийн ханшийн сулрал харьцангуй удаан, аажим байсан байна. 2015 оны 11-р сарын 1-ний байдлаар түүхий эдийн валютуудын ханшийг 2011 оны 11-р сартай харьцуулахад дундаж сулралт нь 70% хувь байгаа бол төгрөг 55%-иар суларсан байна (Зураг 36). Хэдийгээр төгрөгийн ханшийг барьж тогтоон аажим сулруулах бодлого нь маш муу бодлогын хувилбар биш боловч “аажим буцалж буй халуун усанд сууж буй мэлхий”-тэй адил юм.

Зураг 36. Түүхий эдийн валютуудын ам.доллартай харьцах ханш



Эх сурвалж: Монгол банк, Судалгааны багийн дүн шинжилгээ

⁴2010 оны 10-р сарын 1-ний өдрийн ханшийг 1 болгон индексжүүлж ам.доллартай харьцах ханшуудыг тооцсон болно.

Монголбанкны явуулж буй бодлогыг “бохир хөвөгч ханшийн систем” гэж нэрлэх нь түгээмэл. Тус бодлогын үед Төв банкны ил тод, нээлттэй байдал уналтад орж тодорхойгүй байдлыг улам бүр нэмэгдүүлдэг. Бохир хөвөгч ханшийн системийг ихээхэн хэмжээний гадаад валютын нөөцтэй орнууд тодорхой хугацаанд явуулдаг.

Монголбанкны хэрэгжүүлж буй бодлогын дүнд гадаад валютын нөөц шавхагдаж, ОВУС, донор байгууллагуудын тулгалтаар мөнгөний бодлого хэрэгжих шаардлага тулгарах; зах зээлд долларжих үзэгдэл газар авч, төгрөгт итгэх итгэл суларч,

⁴ Commodity currency буюу түүхий эдийн валют гэдэг нь экспортын дийлэнх хэсгийг нь түүхий эд материал эзэлдэг орнуудын валют юм..

төгрөг хэрэглээнээс хасагдах; валютын хар зах ханшийг тодорхойлж, эдийн засгийн зардал нэмэгдэх; эдийн засгийн тогтворгүй байдал үүсэх сөрөг үр дагавар бий болгох эрсдэлтэй.

Валютын ханшийн өөрчлөлт нь төсөвт эерэг ба сөрөг байдлаар нөлөөлнө.

Валютын ханшийн өсөлт нь уул уурхайн экспортын орлогын татвар, импортын барааны гаалийн татварын төгрөгөөр илэрхийлэгдэх дүнг өсгөх эерэг нөлөөтэй бол худалдан авах чадварын бууралттай холбоотойгоор төлөвлөсөн импортын орлого буурах, төсвийн он дамжсан хөрөнгө оруулалтын төслүүд ханшийн зөрүүний алдагдалд орох, улсын төсвөөр санхүүжих бараа, үйлчилгээний зардал өсөх, хөрөнгө оруулалтын зардал өсөх, хүүний зардал өсөх, гадаад өрийн төгрөгөөр илэрхийлэгдэх дүн өсч, ханшийн алдагдалд орох зэрэг сөрөг үр дагаварыг бий болгоно (Зураг 37).

Зураг 37. Валютын ханшийн төсөвт үзүүлэх нөлөөлөл




Эх сурвалж: Судалгааны багийн дүн шинжилгээ

**ДОЛОО. ЗАСГИЙН ГАЗРЫН ӨРИЙН УДИРДЛАГА БА ОЛОН УЛСЫН
БАЙГУУЛЛАГУУДЫН БАЙР СУУРЬ**

Засгийн газрын өрийн ӨҮЦ-ээр илэрхийлсэн үлдэгдэл ДНБ-ий 54.4%-тай тэнцэнэ. Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд өөрчлөлт орсон.

2016 онд Засгийн газрын өрийн ӨҮЦ-ээр илэрхийлсэн үлдэгдэл ДНБ-ий 54.4%-тай тэнцэхээр байна (Зураг 38). Энэ нь Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 6.1.4 “Засгийн газрын өнөөгийн үнэ цэнээр илэрхийлэгдсэн үлдэгдэл нь тухайн жилийн оны үнээр тооцсон ДНБ-ий 40 хувиас хэтрэхгүй байх” гэсэн заалтыг хангахгүй байгаа ба 2015.02.18-д тус хуулийн 19.3-т “...2016 оны төсвийн жилд 55 хувиас хэтрүүлэхгүй байна” гэсэн өөрчлөлт оруулсан.

Зураг 38. Засгийн газрын өрийн үлдэгдэл




Эх сурвалж: Сангийн яам, Судалгааны багийн дүн шинжилгээ

Дахин санхүүжилт хийх, санхүүжилтийн нөхцөлийг өөрчлөх тохиолдолд хүүний түвшин өндөр болно.

Засгийн газрын гадаад зээл, Засгийн газрын баталгаа бүхий гадаад өрийн нийт эргэн төлөлтийн хуваарийг дунд хугацаанд авч үзвэл 2017, 2018, 2022 онуудад томоохон төлбөрүүд хийгдэхээр байна (Зураг 39). 2017 болон 2018 онд хийгдэх зээлийн үйлчилгээний төлбөрүүд нь Монгол улсын гадаад валютын нөөцөөс их байгаа тул дахин санхүүжүүлж (re-financing), санхүүжилтийн нөхцөлийг өөрчлөх магадлал ихтэй байна. Дахин санхүүжилт хийх нөхцөлд хүүний түвшин өндөр болно.

Зураг 39. Засгийн газрын нийт гадаад өрийн эргэн төлөлт




Эх сурвалж: Сангийн яам, Судалгааны багийн дүн шинжилгээ

Монгол улсын бодлого, институцийн чадавхийн үнэлгээ буурч байна.

Дэлхийн банк болон ОУВС-ийн зүгээс бага орлоготой орнуудын өрийн тогтвортой байдлын шинжилгээгээр бодлого болон институцийн чадавх сайн байх тусам өрийг удирдах боломжтой байдаг тухай үзүүлсэн байдаг. CPIA (Country Policy and Institutional Assessment) буюу улсын бодлого, институцийн үнэлгээ нь улс орнуудыг 1-6 оноогоор үнэлдэг ба үнэлгээ өндөр байх нь тухайн улсын бодлого болон институц сайн байгааг илэрхийлдэг. Монгол Улсын хувьд уг үнэлгээ буурч байгаа бөгөөд бодлого, институцийн чадавхи сул ангилал руу ойртож байна (Зураг 40).

Зураг 40. Монгол улсын бодлого ба институцийн чадавхийн үнэлгээ



Эх сурвалж: Дэлхийн банкны статистик мэдээлэл

Монгол Улсын өрийн тогтвортой байдлын үзүүлэлтүүд хангалтгүй, өрийн хямралд орох эрсдэл өндөр хэвээр байна.

ОУВС-ийн 2015 оны “Өрийн тогтвортой байдлын шинжилгээ-Монгол Улс” судалгааны тайланд Монгол Улсын өрийн тогтвортой байдлын үзүүлэлтүүдийг таамаглажээ (Хүснэгт 2). Тус тайланд “Монгол Улсын өрийн тогтвортой байдлын үзүүлэлтүүд хангалтгүй байгаа бөгөөд өрийн хямралд орох эрсдэл өндөр хэвээр байна. Эрх баригчид бодлогоо улам чангатгах хэрэгтэй” гэж дурьджээ.

Хүснэгт 2. Монгол улсын өрийн тогтвортой байдлын үзүүлэлтүүд (таамаглал)

	2016	2017	2018	2019	2020
Нийт гадаад өр (нэрлэсэн)/ДНБ%	187.8	181.7	173.3	164.3	153.8
Улсын өр (нэрлэсэн)/ДНБ%	87.6	92.6	89.1	84.9	80.1
Үүнээс: Гадаад валютын өр/ДНБ%	62.4	60.2	58.4	56.2	54.0
Улсын өрийн ӨҮЦ/ДНБ%	64.6	63.4	61.0	58.3	55.8
Улсын гадаад өрийн ӨҮЦ-ийн засгийн газрын орлогод эзлэх %	259.3	255.6	240.9	230.0	216.9
Улсын гадаад өрийн ӨҮЦ-ийн экспортод эзлэх %	151.8	170.5	167.0	151.3	133.6
Улсын өрийн үйлчилгээний экспортод эзлэх %	8.2	32.8	12.4	11.9	9.1
Улсын өрийн үйлчилгээний засгийн газрын орлогод эзлэх %	14.1	49.1	17.8	18.1	14.7

Эх сурвалж: Debt sustainability analysis, IMF, 2015

Монгол улсын зээлжих зэрэглэл өнгөрсөн онтой харьцуулахад дахин буурсан.

Олон улсын зээлжих зэрэглэлийг үнэлдэг S&P ба TE байгууллагууд Монгол улсын зээлжих зэрэглэл “B1”-ийг хэвээр нь үлдээсэн боловч хэтийн төлөвийг бууруулж “тогтвортой” байсныг “сөрөг” болгосон. Зээлжих зэрэглэлийн төлөв өөрчлөгдөх нь үнэлгээ өөрчлөгдөх эхний алхам болдог ба сөрөг төлөвийг хагас шат буурсан гэж үздэг байна. Монгол улсын “сөрөг” төлөв байдлыг гадаад өрийн хэмжээ өссөн, гадаад валютын нөөц багассан, гадаадын шууд хөрөнгө оруулалт буурсан, дотоод зээлийн хэмжээ өссөнтэй холбон тайлбарлажээ.


Хүснэгт 3. Монгол улсын зээлжих зэрэглэл

	2014.11.07	2015.11.01
S&P	B+ тогтвортой	B+ сөрөг
Moody's	B2 сөрөг	B2 сөрөг
Fitch	B+ сөрөг	B+ сөрөг
TE	34 тогтвортой	34 сөрөг

Эх сурвалж: www.tradingeconomics.com

Хөгжиж буй орнуудын өрийн асуудлыг судалдаг Их Британид төвтэй “Jubilee Debt Campaign” төрийн бус байгууллагаас засгийн газрын гадаад өр нь хямралд орох эрсдэлтэй 14 орны тоонд Монгол улсыг багтаажээ. Тус байгууллага нь гадаад өрийн хэмжээ ДНБ-ий 30%-иас давсан, төсвийн алдагдал ДНБ-ий 5%-иас давсан, өрийн эргэн төлөлт Засгийн газрын орлогын 10%-иас давсан бол өрийн хямралд орох өндөр эрсдэлтэй орон гэж үздэг байна. Иймд Монгол Улс Засгийн газрын өрийн удирдлагын зөв бодлого хэрэгжүүлж, өрийн хямралд орох эрсдэлээс сэргийлэх шаардлага тулгараад байна.

Зураг 41. Засгийн газрын гадаад өрийн хямралд орох магадлалтай орнууд (Jubilee Debt Campaign)



Эх сурвалж: Jubilee Debt Campaign

НАЙМ. ЕРӨНХИЙ ДҮГНЭЛТ БА ЗӨВЛӨМЖ

2016 оны нэгдсэн төсвийн төсөлд хийсэн тойм судалгааны дүнг хураангуйлан дүгнэвэл:

Төсвийн орлогын төлөвлөлтийн хувьд:

- Төсвийн орлогыг Монгол Улсын эдийн засгийн идэвх сэргэх таамаглалд тулгуурлан төлөвлөжээ. Уул уурхайн салбарын орлогын төлөвлөлт өмнөх жилүүдтэй харьцуулахад илүү бодитой болсон ч дэлхийн улс орнууд болон БНХАУ-ын эдийн засгийн өсөлт удааширч, дэлхийн түүхий эдийн зах зээлийн ирээдүйн төлөв байдал тодорхойгүй байгаа нөхцөлд төсвийн орлого бүрдэлтэд эрсдэл учирч болзошгүй байна.

Төсвийн зарлагын төлөвлөлтийн хувьд:

- Бүтцийн өөрчлөлт хийх замаар цалин хөлс, НДШ-ийн зардлыг бууруулна.
- Зээлийн үйлчилгээний төлбөр, татаасын хэмжээ өснө.
- Төсвийн хөрөнгө оруулалтын хэмжээ буурах ба өмнөх онуудад эхэлсэн он дамжсан төслүүдэд дийлэнх хувь зарцуулагдана.

Төсвийн тэнцэл:

- Нэгдсэн төсвийн алдагдал өндөр хэвээр байна.

Өрийн удирдлага:

- Төсвийн он дараалсан алдагдлыг санхүүжүүлэх эх үүсвэр нь Засгийн газрын өрийн дарамтыг нэмэгдүүлсэн.
- Өрийг дахин санхүүжүүлэх, санхүүжилтийн нөхцлийг өөрчлөх нь өртөг өндөртэй.
- Монгол Улсын өрийн тогтвортой байдлын үзүүлэлтүүд муудаж, зээлжих зэрэглэл дахин буурсан.

Зөвлөмж

Дээрх дүгнэлтэд үндэслэн төсвийн төлөвлөлтийг сайжруулах талаар дараах зөвлөмжийг гаргаж байна. Үүнд:

Төсвийн орлого төлөвлөлтийн хувьд:

- 2016 оны эдийн засгийн нөхцөл байдлын таамаглалыг харгалзан төсвийн орлогыг бодитой төлөвлөх.

Төсвийн зарлагын хувьд:

- Төсвийн зарцуулалтын үр ашиг, ил тод байдалд өндөр шаардлага тавих.
- Орон нутагт төсвийн эрх мэдлийг шилжүүлэхдээ төсвийн хөрөнгийн зарцуулалтад тавих хяналтыг сулруулахгүй байх.
- Төсвийн хариуцлагыг дээшлүүлэхийн тулд төсвийн орлого төлөвлөлтийг сайжруулж, төлөвлөснөөс илүү гарсан орлогын зарцуулалтыг хууль тогтоох байгууллагаар батлуулдаг болох.

Хөрөнгө оруулалтын төлөвлөлтийн хувьд:

- Улс орны нийгэм, эдийн засгийн хөгжилд нэн тэргүүний ач холбогдол бүхий төслүүдийг хэрэгжүүлэхээр төлөвлөх.
- Төсвийн хөрөнгөөр гүйцэтгэх хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх болон гүйцэтгэлд нь хяналт тавих ажлыг сайжруулах;

Төсвийн тэнцлийн хувьд:

- 2016 оны төсвийн алдагдлыг бууруулах.

- Төсөвт тавих хяналтыг эрс нэмэгдүүлэх, баталсан түвшнээс илүү алдагдал бий болгохгүй байх.
- Төсвийн алдагдлыг баталсан түвшнээс хэтрүүлсэн тохиолдолд хариуцлага тооцдог байх.

АШИГЛАСАН МАТЕРИАЛ

1. Монгол улсын 2016 оны төсвийн төслийн баримт бичгүүд (төсвийн хуулийн төслүүд, төсвийн төслийн дэлгэрэнгүй танилцуулга)
2. 2010-2015 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлангууд
3. Төсвийн тухай хууль (2011)
4. Төсвийн тогтвортой байдлын тухай хууль (2011)
5. Монголбанк (2015). *Төрөөс мөнгөний бодлогын талаар 2016 онд баримтлах үндсэн чиглэлийн төсөл*
6. Үндэсний Аудитын Газар (2015). *Монгол улсын 2016 оны төсвийн төсөлд өгөх санал, дүгнэлт*
7. ОУВС (2015). *Дэлхийн эдийн засгийн тойм*
8. ОУВС, Рио Тинто (2015). *Дэлхийн түүхий эдийн зах зээлийн тойм*
9. Дэлхийн банк (2015). *Монгол улсын эдийн засгийн тойм*
10. ОУВС (2015). *The Debt Sustainability Analysis-Mongolia*
11. Bloomberg Financial Conditions Index, Goldman Sachs Financial Conditions Index
12. БНХАУ-ын Үндэсний Статистикийн Төв Хорооны мэдээллүүд
13. Рио Тинто хэвлэлийн мэдээлэл
14. Монгол Улсын Үндэсний Статистикийн Хорооны мэдээллүүд
15. Бусад